



ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ ТАРХАЛТЫН МЭДЭЭ

Хоёр долоо хоног тутмын мэдээ №18

Нэг. Монгол оронд бүртгэгдсэн шувууны томуугийн сэжигтэй тохиолдлын мэдээлэл:

2022 оны 10-р сарын 12 ноос 10-р сарын 25 ны хооронд шувууны томуугийн холбогдолтой өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй.

Хараалж (1), алаг хөөндэй (1), тагтаа (1) зэрэг 3 зүйл шувуу шилэн байшин, цонх мөргөж гэмтсэн тохиолдол Улаанбаатар хотод 2022 оны 9-р сараас 10-р сарын хооронд бүртгэгдсэн байна. Эх сурвалж: *Монголын шувуу ажиглагчдын клуб*

Хоёр. Шувууны томуугийн хүний өвчлөлийн олон улсын мэдээлэл:

2022 оны 10-р сарын 12-25 ны хооронд шувууны томуугийн А хүрээний H5N1, H3N8, H7N9, H9N2, H6N1, H10N8, H7N4, H5N8, H10N3 вирусын хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна.

А хүрээний **H5** вирусын хэв шинжээр хүний өвчлөлийн 1 тохиолдол Вьетнамд бүртгэгдсэн. Вьетнам улсын эрүүл мэндийн яамны урьдчилан сэргийлэх анагаах ухааны газрын дэд дарга доктор Nguyen Luong Tam Фү Тоо мужийн 5 настай эмэгтэй хүүхэд шувууны томуу (А/Н5) ханиадаар өвдсөн тухай 2022 оны 10 сарын 20 нд мэдээлсэн. 2014 оны 2-р сараас хойш бүртгэгдэж байгаа анхны тохиолдол болж байна. 2003 оноос хойш тухайн улсад нийт 128 тохиолдол үүнээс, 64 нас баралт бүртгэгдэж байсан. Тухайн бүс нутагруу явуулын лаборатори илгээж, хариу арга хэмжээг шуурхай авч ажиллаж байна гэж халдварт өвчин судлалын төвийн дэд дарга Tran Nhu Duong мэдээлсэн. Өвчтний ойрын болон дам хавьтал болох 65 хүнээс сорьц авч шинжилсэн ба бүгд сөрөг байсан.

А хүрээний **H5N6** вирусын хэвшинжээр хүний өвчлөлийн 1 тохиолдол БНХАУ д бүртгэгдэв. Гуанси мужийн Наньнин хотод 3 настай хүү 9-р сарын 1 нээс өвчний шинж тэмдэг эхэлж 11 нээс эмчилгээг эхэлсэн одоогоор өвчтний биеийн байдал хүнд байна гэж Хонконгийн эрүүл мэндийн байгууллага мэдээлсэн. 2014 оноос хойш хүний өвчлөлийн 81 тохиолдол бүртгэгдээд байна.

Гурав. 2022 оны 10-р сарын 12 ноос 10-р сарын 25 ны хооронд шувууны томуугийн А хүрээний вирусээр өвчилсөн хүний болон шувууны мэдээлэл:

2022 оны 10-р сарын 12-25 ны хооронд шувууны томуугийн А хүрээний вирус Франц, Герман, Испани, Өмнөд Африк, Голланд, Норвеги, Бельги, Колумби, Фарерын арлууд, Словени, Исланд, Итали, Мексик, АНУ, Өмнөд Солонгос, ОХУ, Ирланд, зэрэг 17 улс орны газар нутагт нүүдлийн болон тэжээвэр шувуудын дунд 63 тохиолдол бүртгэгдсэн (Дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгт 1, зураг 1 ээс харна уу). Хун, галуу, нугас зэрэг нүүдлийн усны 22 зүйлийн шувуу, хөхтөн амьтны 1 зүйлд өвчлөл бүртгэгдсэн байна.

(Хүснэгт 1) Шувууны томуугийн А хүрээний вирусын хэв шинжээр тархалт

Дэд хэвшинж	Улс	Зүйлийн нэр	Нийт тохиолдол
H5N1 HPAI	Бельги	Branta Canadensis, буурал галуу, алагтуу, эгэл шонхор, шар шувуу, сар шувуу, тахиа	13
H5N1 HPAI	Колумби	Ногоохон нугас, тахиа	2
H5N1 HPAI	Фарерын арлууд	Хон хэрээ, тагтаа, цахлай	4
H5N1 HPAI	Франц	Тахиа	5
H5N1 HPAI	Герман	Цацагт хяруул, тахиа	3
H5N1 HPAI	Исланд	Morus bassanus, хүрэн толгойт цахлай, Stercorarius skua	3
H5N1 HPAI	Ирланд	Тахиа	1
H5N1 HPAI	Остров Мэн	Турлиах	1
H5N1 HPAI	Итали	Зэрлэг нугас, ногоохон нугас, буурал галуу, тахиа	8
H5N1 HPAI	Мексик	Шонхор	1
H5N1 HPAI	Голланд	Тахиа, цацагт хяруул	7
H5N1 HPAI	Норвеги	Тахиа	1
H5N1 HPAI	Өмнөд Солонгос	Тахиа	1
H5N1 HPAI	ОХУ	Тахиа	1
H5N1 HPAI	Словени	Гунгар хун	1
H5N1 HPAI	Өмнөд Африк	Тахиа	2
H5N1 HPAI	Испани	Булга /тэжээвэр/	1
H5N1 HPAI	АНУ	Хун, галуу, нугас тахиа	5

Эх сурвалж: <https://empres-i.apps.fao.org/>

(Зураг 1) 2022 оны 10-р сарын 12-25 ны хооронд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусын тохиолдлын тархалт

